Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд зарим өөрчлөлтүүд орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн захирлын 2023 оны 10 сарын 23-ны өдрийн А/29 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.9 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	133,767.20	205,378.80	(71,611.60)
Авлага	-	-	-
Урьдчилгаа	20,470.00	-	20,470.00
Бараа материал	149,691.80	149,679.40	12.40
Үндсэн хөрөнгө	4,036,691.80	4,415,455.40	(378,763.60)
Нийт хөрөнгө	4,340,620.80	4,770,513.60	(429,892.80)
Өр төлбөр	6,932.30	82,147.80	(75,215.50)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,333,688.50	4,688,365.80	(354,677.30)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,340,620.80	4,770,513.60	(429,892.80)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, үндсэн хөрөнгө, өглөг дансанд өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан байна.

Сургууль нь оны эхэнд 133.7 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байснаа оны эцэст 205.4 сая төгрөгийн харицлахын үлдэгдэлтэй гарсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдэж

гардаг шалтгаан нь жилийн эцсийн төсөв гүйлгээ хаах хугацаанд тулгаж ирсэн тул НДШ-ийн болон ХХОАТ-ын 78.7 сая төгрөгийн гүйлгээг хийж чадалгүй өртэй гарсантай холбоотой байна. Зарцуулагдаагүй төсвийн дийлэнх үлдэгдлийг бараа үйлчилгээний бусад зардал, хоолны зардал, үдийн цайны зардал, мэдээлэл технологийн үйлчилгээ болон цалин, НДШ-ийн зардлууд эзэлсэн байна.

Оны эцэст төсвөөс авсан санхүүжилтээс мөнгөн хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

Оны эхэнд байсан урьдчилж гарсан зардлын 20.5 сая төгрөгийг тайлант онд барагдуулсан байна.

Бараа материалын үлдэгдэлд бага хэмжээний өөрчлөлт орсон байна. Төсвийн хөрөнгөөр 232.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан. Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал байхгүй байна. Тайлант онд 253.9 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 146.6 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна. Акталсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 511.0 сая төгрөгөөр нэмэгдсэн. Төсвийн хөрөнгөөр 55.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн худалдан авч, бусад эх үүсвэрээр нийт 494.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авсан байна. Тайлант онд 35.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 3.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгөд 132.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүнгээр 354.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3250.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3250.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 190.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3,440.6 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 15 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 3,361.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 363.6 сая сая төгрөгийн санхүүжилтийг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 4.5 сая төгрөгийн орлогыг оруулж, урьд оны үлдэгдлээс 132.1 сая төгрөгийг санхүүжүүлж, нийт 3861.4 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,361.2 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 362.4 сая төгрөгийн санхүүжилтийг авч, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 4.5 сая төгрөгийн орлогыг оруулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,656.5 сая төгрөг буюу 94.7 хувьтай байна.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	5,082.40	4,956.20	126.20	97.52
80233	Хїхэд хамгаалал	5282.2	3282.2	2,000.00	62.14
80312	Сургалт семинар	3,929.00	3,130.00	799.00	79.66
81605	Эрүүл мэндийг дэмжих	7,006.00	1,655.00	5,351.00	23.62
81801	үдийн цай хөтөлбөр	96,639.00	66,894.50	29,744.50	69.22
81806	Дотуур байрны үйлчилгээ	686,225.00	618,078.40	68,146.60	90.07
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	36,712.40	36,657.20	55.20	99.85
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	16,708.70	810.00	15,898.70	4.85
81827	Бичиг үсгийн боловсролын хөтл	35,904.50	35,429.20	475.30	98.68
81834	Боловсролын стандарт, сургалты	2,576,083.90	2,503,168.70	72,915.20	97.17
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	15,192.70	15,192.70	0.00	100.00
81848	Сурах бичгийн тїрээс	4,888.60	4,845.80	42.80	99.12
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	8,163.20	0.00	8,163.20	-
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	363,630.00	362,400.30	1,229.70	99.66
	Дүн	3,861,447.60	3,656,500.20	204,947.40	94.69

Тайлант оны орон нутгийн санхүүжилтээс төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө байхгүй байна. Оны эцэст зарцуулагдаагүй 205.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн тайлангийн аудитын ерөнхий чиглэлийн судалгааны талаар:

Цалингийн сангаас ахмадын санг бүрдүүлээгүй.Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна.Босго үнэ буюу 20.0 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий хоолны зардлыг болон үдийн хоолны зардлыг тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй байна.

Тайлант онд 118 орон тоогоор ажилласан.Урьд он буюу 2024 онд нийт 124 орон тоогоор ажиллаж, орон тоо 6 хүнээр нэмэгдсэн байна. Шалтгаан нь: Хөвгүүдийн дотуур байр нэмэгдсэнээр 6 хүний оорн тоо шинээр нэмэгдсэн байна.Сурах бичгийн түрээсийн орлогоос 4.5 сая төгрөгийг оруулсан.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Батлагдсан төсвийн хүрээнд 232.6 сая төгрөгийн бараа материал, 55.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2025/04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,746.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 27.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,243.7 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 42.4 сая төгрөг болж байна.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нийт орлого, зардалд өмнөх оноос өөрчлөлт орсон байх тул материаллаг байдлыг гүйцэтгэлийн шатанд шинээр тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтийн хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил дараах зөрчлүүд илэрсэн.

1.Тайлант оны эхэнд худалдан авалтын төлөвлөгөөг гаргаж, батлуулаагүй, хоолны болон үдийн цайны зардлын нийт төсөвт тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй, шууд гэрээ хийх замаар худалдан авалт хийсэн байна.Төсвийн хөрөнгөөр 4 газраас 23.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шууд гэрээ хийх замаар худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 14.2-т “Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ”, 4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жилийн эхэнд батлуулж, 20.0 сая төгрөгөөс дээш өртөгтэй бараа, ажил үйлчилгээг худалдаж авах захиалгыг сумын ТТЗ-д нэгтгүүлэн, худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг, байгууллагад шаардлагатай техник тоног, төхөөрөмж, тавилгыг цахим дэлгүүрээс худалдан авахыг зөвлөмж болгов.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 3208.3 сая төгрөгийн орлогыг, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 81.7 сая төгрөгийн 10 мөнгөн гүйлгээг мэдээлсэн байна. Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100.0 хувьтай байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн. Аудитаар уулзалт хийж, байгууллагын талаар мэдээлэл, дотоод аудитын талаар мэдээлэл авч, холбогдох ажлын баримтуудыг цуглуулсан. Нөлөөллийн мэдүүлгийн баримтыг танилцуулж, гарын үсэг зуруулж, уулзалтын тэмдэглэлийг баримтжуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар сургуулийн дотуур байрны багшид албан тушаалын ангилал зэрэглэл, орон тооны жишиг нормативт тусгагдаагүй дотуур байрны эрхлэгч гэсэн албан тушаалаар жилийн турш ТҮБД-4 шатлалаар цалинжуулж, нийт 2055.1 мянган төгрөгийн цалинг илүү олгосонд төлбөрийн акт,

Сургууль нь орон тооны жишиг нормативт тусгагдаагүй байхад захирлын 2023 оны 10 сарын 06 өдрөөрх тушаалаар няравын орон тоог шинээр бий болгож, 3 сарын туршид нийт 2959.9 мянган төгрөгийн цалинг олгосныг сургуулийн захирлаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон байна.

Батлагдсан орон тоог Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 дугаар тушаалаар баталсан орон тооны жишиг нормативтай харьцуулж үзэхэд 7 орон тоог илүү ажиллуулж, төсвөөс 40561.7 мянган төгрөгийн зардал гаргасанд,

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зардлын 102.8 сая төгрөгийн 8 мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 90.6 хувьтай байгаад зөвлөмж өгөгдсөн байна.

Дээрх зөвлөмжийн мөрөөр өгсөн зөвлөмжийг биелүүлэн, зөрчлийг арилган ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	5,015.0	2	5,015.0	100%
Албан шаардлага					
Зөвлөмж	2	143,363.2	2	143,363.2	100%
Нийт дүн	4	148,378.2	4	148,378.2	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлалтаас цалин олголт, цалин тогтоолтыг бүрэн шалгаж амжаагүй тул дараагийн аудитаар цалинг үнэн зөв олгосон эсэхийг дахин шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 154,792.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 154,792.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Залруулсан алдаа:

- Гэрэл цахилгааны зардлыг 14,404.7 мянган төгрөгөөр илүү, түлш халаалтын зардлыг дутуу тусгасныг залруулсан.
- Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан 55,849.0 мянган төгрөгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авах хэсэгт тусгаагүй байсныг залруулсан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний дүн 84,538.8 мянган төгрөгөөр дутуу тусгасныг залруулсан.

Энэ нь Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам", УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 67,004.4 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 1,471.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 65,533.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар 1,471.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгөв.

1. Санхүүгийн ажилтанд цалингаас 1,471.0 мянган төгрөгийн балансын шагнал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

Аудитаар 65,533.4 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотуур байрны хүүхдийн хоолны бүртгэл, тооцоотой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Дотуур байрны хүүхдийн хоолны талоныг бичихдээ ахлах, бага, дунд бүлэгт сурдаг хүүхдийн тоогоор ангилаагүй нийт хүүхдийн тоогоор бичиж ирсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2022 оны 498 дугаар тогтоолоор баталсан "Хоолны норматив тогтоох тухай" журмын 2-т "Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах ахлах ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4300 (дөрвөн мянга гурван зуун) төгрөгөөр, бага, дунд ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4000 (дөрвөн мянган) төгрөгөөр тус тус тогтоосугай" гэсэнд нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Дотуур байрны хүүхдийн хоолны талоныг ахлах, дунд бүлэгт сурдаг хүүхдийн тоогоор ангилан бичиж, нормативыг баримтлан ажиллах,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

2.1.Илрүүлэлт:

Сургууль нь бараа материалын тайланг хугацаанд гаргаж тайлагнаагүй, жилийн дүнгээр нэгтгэж тайлагнаж ирсний дээр тайлант онд сургуулийн хэрэгцээнд зарцуулсан 11,246.5 мянган төгрөгийн шатахуун, 20,505.7 мянган төгрөгийн хичээл практик, 9,791.2 мянган төгрөгийн аж ахуйн зардлын зарцуулалтад зохих журмаар хяналт тавьж ажиллаагүй байна.

Тухайлбал: Шатахуун олгосон жагсаалт үйлдээгүй, ямар ажлаар хаашаа явсан нь тодорхойгүй, шатахуун хүлээн авсан хүний жагсаалт үйлдээгүй, хичээл практикийн зардлын захиалгын нэгтгэл хийгээгүй, хичээл практик, аж ахуйн зардлын тараалтын жагсаалтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, бараа материалын тайланг сараар нэгтгэж гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх” 14.3.2-д “журналд бичих” 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого”, 14.4.6-д “бүх зардал” гэсэнд нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Няравын бараа материалын тайланг сар бүр хөтлөх, анхан шатны баримтыг хууль журмын дагуу бүрдүүлэх, бараа материалын тараалт үйлдэх, хүлээн авсан хүний гарын үсэг зуруулах, санхүүгийн хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлэх.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт:

1.Тайлант оны эхэнд худалдан авалтын төлөвлөгөөг гаргаж, батлуулаагүй, хоолны болон үдийн цайны зардлын нийт төсөвт тендер зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулаагүй, шууд гэрээ хийх замаар худалдан авалт хийж ирсэн байна.Сургууль нь Нэксст электроникс ХХК-аас 13,229.0 мянган төгрөгийн, Бат болосвролын үр ХХК-наас 7,365.0 мянган төгрөгийн, Алтантоонот Алтай ХХК-наас 1,020.0 мянган төгрөгийн, Майтеч ХХК-наас 2,376.0 мянган төгрөгийн, нийт 23,990.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авахдаа шууд гэрээ хийх замаар худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 14.2-т “Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ”, 4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.2. Өгсөн зөвлөмж:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жилийн эхэнд батлуулж, 20.0 сая төгрөгнөөс дээш өртөгтэй бараа, ажил үйлчилгээг худалдаж авах захиалгыг сумын ТТЗ-д нэгтгүүлэн, худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг, байгууллагад шаардлагатай техник тоног, төхөөрөмж, тавилгыг цахим дэлгүүрээс худалдан авахыг зөвлөмж болгов.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг үнэн зөв тайлагнаагүй	3	154,792.5	0	0	3	154,792.5	3	154,792.5				
Дүн	3	154,792.5	0	0	3	154,792.5	3	154,792.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотуур байрны хүүхдийн тоог ангилаагүй	1	0					1	0				
Бараа материалын тайланг хугацаанд гараагүй, зарим зардлын зарцуулалтад тавих хяналтыг сулруулсан	1	41,543.4					1	41,543.4				
Санхүүгийн ажилтанд балансын	1	1471.0			1	1471.0						

Алтай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

урамшуулал олгож, урамшуулал олгох хэмжээг хэтрүүлсэн												
Худалдан авалтын төлөвлөгөөг батлуулаагүй, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	23,990.0				1	23,990.0					
Дүн	2	67,004.4			1	1471.0	3	65,533.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								